



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 08 сарын 03 өдөр

Дугаар A/117

Биндэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсыг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, "Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалт"-аар гүйцэтгэх ан амьтан, газар, ойн чиглэлээр гүйцэтгэх ажлуудыг хүлээн авах, дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Болор-Эрдэнэ (Байгаль хамгаалагч)

Гишүүд:

Ч.Оюунбат (Байгаль хамгаалагч)

А.Гэрэлмаа (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Э.Мөнгөншагай (Мандалхаан багийн Засаг дарга)

Г.Амгаланцэцэг (Нягтлан бодогч)

2.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалтаар гүйцэтгэх ажлуудыг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хүлээн авах, дүгнэх ажлыг батлагдсан норм, стандарт, техникийн нөхцөлд тулгуурлан сонгон шалгаруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

